

БАТЛАВ
ЗАСАГ ДАРГА

2024 оны 02 сарын 20 өдөр

П. АЛТАНХУЯГ

АРХАНГАЙ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ФОНДОД ӨВС ТЭЖЭЭЛ
ХУДАЛДАН АВАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024.02.20

Баянцагаан

Худалдан авах ажиллагааны зорилго: Хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан сумын фондод өвс, тэжээл худалдан авч нөөц бүрдүүлж малчдад хөнгөлөлтэй үнээр борлуулах, тэдэнд түргэн шуурхай хуваарилан түгээх.

Байршил хаяг: Архангай аймгийн Жаргалант сумын Баянцагаан баг 1-р хороо Засаг даргын тамгын газар

Хөрөнгө оруулалт: Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр 50.000.000 /Тавин сая төгрөг/

Барааны тодорхойлолт: 2023 онд бэлтгэсэн шинэ ургацын байгалын хадлангийн өвс, улаан буудайн хивэг

Стандарт: [Худалдан авах өвс нь гарал үүслийн гэрчилгээтэй байх. Малын халдварт өвчин гарч байгаагүй газраас бэлтгэсэн байх]

Нарийн шивээгүй, харганагүй, сав баглаа боодол задраагүй, стандарт жин хэмжээтэй байх.

Баглаа, боодол: [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг үйлдвэрлэгч өөрөө хариуцна. Гологдолтой барааг хүлээж авахгүй.]


Бараа хүргэх газар: [Барааг Архангай аймгийн Жаргалант сумын төвийн өвс тэжээлийн агуулахад буулгаж хүлээлгэж өгнө.]

Хөрөнгө оруулагч /захиалагч/ байгууллага:
Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар

ТАВИГДАХ ШААРДЛАГА

№	Техникийн тодорхойлолт	Хэмжих нэгж /кг/	тоо ширхэг /ш/	Нийт хэмжээ /кг/
1	Муудаж, ялзарч харлаагүй, ногоон, шинэ ургацын орос прессээр боосон өвс байх (задарч бутарсан, ялзарсан, харгана голдуу болон өнжмөл өвсийг шаардлага хангаагүй гэж үзнэ)	25 кг-аар	1000	25000
2	Улаан буудайн хивэг	25 кг	800	20000
3	Фондод нийлүүлэх өвс, хивэгийг ЗДТГ-ын нөөцийн агуулахад хүргэж, хураан няравт хүлээлгэн өгөх			

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН :



Г.БАЯРБЯМБА
О.АМАРБАЯСГАЛАН
Л.БАЙГАЛЬЦЭЦЭГ